

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хамтын санхүүжилтийн тухай хуулийн төслийн талаар


Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг баталсан. Тус үндсэн чиглэлийн 84-т “Хамтын санхүүжилтийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхийг даалгасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.4.4-т “Шинжлэх ухаан, инновацын салбарт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэл бий болгож, гадаадын дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн соёлыг төлөвшүүлнэ.”, 3.3.15-д “Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.”, 4.5.10-т “Санхүүжилтийн бусад эх үүсвэр, лизинг болон факторингийн талаарх ойлголт, хэрэглээг нэмэгдүүлж, экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд зориулсан батлан даалт, даатгалыг нэвтрүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 50¹ дүгээр зүйлийн 50^{1.1}-т “Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь тусгай программ хангамжаар дамжуулан гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон хөрөнгө оруулагчийн хооронд санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг үр ашигтайгаар зохион байгуулна.” гэж заасан.

Хамтын санхүүжилт гэдэгт бизнесийн шинэ санаа, төслийг санхүүжүүлэх зорилгоор цахим технологийг ашиглан хувь хүн, аж ахуйн нэгжээс хөрөнгө татан төвлөрүүлэх үйл ажиллагааг ойлгох бөгөөд энэ тухай ойлголт нь анх 1700-аад оны үед Ирланд улсад бага орлоготой, зээлийн түүхгүй иргэдэд хамтын хөрөнгөөс зээл олгох санаачилгын хүрээнд үүсэж бий болсон түүхтэй.

Улмаар 2000 оны эхэн үед интернет, цахим технологи хөгжихийн хэрээр олон этгээд хоорондоо холбогдон нэгдэж орчин үеийн платформ суурьтай хамтын санхүүжилтийн эхлэлийг тавьсан бөгөөд 2008 оны эдийн засгийн хямралаас үүдэн банкнуудын зээлийн хэмжээ буурснаар бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх салбар болох өрхийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх, санхүүгийн шинэ арга хэрэгслийг бий болгох зорилгоор хамтын санхүүжилт улам ихээр хөгжих болсон.




Зураг 1. Хамтын санхүүжилтийн тогтолцоо

Хамтын санхүүжилт нь дараах үндсэн 4 төрөлтэй:

- Хандивт (donation-based) суурилсан – Сайн үйлсэд зориулан олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх;
- Урамшуулалд (reward-based) суурилсан – Ямарваа нэгэн бүтээгдэхүүн, үйлчилгээг ирээдүйд худалдахаар хөрөнгө татан төвлөрүүлэх;
- Зээлд (debt-based or peer-to-peer lending) суурилсан – Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг бусдад зээлдүүлэх;
- Хувьцаанд (equity-based) суурилсан – Хувьцаа гаргах замаар олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх.

Зураг 2. Хамтын санхүүжилтийн төрлүүд



Эх сурвалж: <https://www.iosco.org/research/pdf/20140410-Risks-and-Benefits-of-Crowdfunding.pdf>

Урамшуулал болон хандивт суурилсан хамтын санхүүжилтийг хамтад нь олон нийтийн хамтын санхүүжилт, зээл болон хувьцаанд суурилсан хамтын санхүүжилтийг хамтад нь санхүүгийн өгөөж хүртэх хамтын санхүүжилт гэж нэрлэдэг. Эдгээр төрлүүдийн гол ялгаа нь урамшуулал болон хандивт суурилсан хамтын

санхүүжилт ямар нэгэн байдлаар хөрөнгө оруулалт эсвэл санхүүгийн өгөөж хуваарилдаггүйд оршино.


Хамтын санхүүжилт нь эхлэлтийн буюу гарааны бизнес эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд бага зардлаар санхүүжилт татан төвлөрүүлэх боломжийг олгодог бөгөөд цаашлаад эдийн засгийн өсөлтийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх, банкны орхигдуулсан орон зайг нөхөх зэрэг ач холбогдлоороо бусад санхүүгийн хэрэгслээс ялгаатай.

Хэдийгээр хамтын санхүүжилт нь дээр дурдсанчлан аливаа улс орны эдийн засгийн гол хөдөлгүүр болсон жижиг, дунд үйлдвэрлэлийг санхүүжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах давуу талтай боловч нөгөө талаараа залилангийн буюу онлайн платформууд хуурамч компани байгуулан хөрөнгө татан төвлөрүүлэх, татан төвлөрүүлсэн хөрөнгийг өөр зориулалтаар ашиглах, хүний санааг зөвшөөрөлгүйгээр хэрэглэх, бизнес дампуурах, хөрөнгө оруулагчдын мэдлэггүй байдал, программ хангамжийн найдваргүй байдал, кибер халдлага, мөнгө угаах зэрэг ихээхэн эрсдэлийг дагуулдаг.

Хамтын санхүүжилт нь бусад санхүүгийн салбартай харьцуулахад ихээхэн шинэлэг салбар */жишээлбэл, Их Британид 2006 оноос, Америкт 2007 оноос, Хятадад 2009 оноос үүсэж эхэлсэн/* тул улс орнууд хамтын санхүүжилтийг зохицуулах хууль, эрх зүйн орчныг сүүлийн жилүүдэд үе шаттайгаар бүрдүүлж байна. Олон улсын туршлагаас үзэхэд эрх баригчид зээл болон хувьцаанд суурилсан хамтын санхүүжилтийг хууль, эрх зүйн хүрээнд зохицуулахаар түлхүү анхаарч байгаа бол урамшуулал болон хандивт суурилсан хамтын санхүүжилтийг ихэнх тохиолдолд тусгайлсан зохицуулалтад хамааруулдаггүй байна. Түүнчлэн ихэнх улс орнууд зээл болон хувьцаанд суурилсан хамтын санхүүжилтийг гарааны болон жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэх үр ашигтай хэрэгсэл гэж үздэгийг дурдах нь зүйтэй. */Хавсралт 1-т АНУ, Япон, Тайланд улсуудын хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны зохицуулалтын талаарх мэдээллийг оруулав./*

Улс орнуудад хамтын санхүүжилтийн үйл ажиллагаагаар дамжуулан санхүүжилт татан төвлөрүүлэх байдал тасралтгүй өсөж байгаа бөгөөд цаашид ч улам нэмэгдэх хандлагатай байна. 2024 оны байдлаар дэлхий дахинаа хамтын санхүүжилтийн платформуор дамжуулан татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийн хэмжээ 166.95 тэрбум доллар байгаа бөгөөд энэ тоо 2032 онд 2,801.29 тэрбум доллар болж өснө гэсэн тооцооллыг судлаачид гаргасан байна.

Хүснэгт 1. Хамтын санхүүжилтийн платформуор татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийн хэмжээ



Эх сурвалж: <https://www.polarismarketresearch.com/industry-analysis/crowdfunding-market>

Олон улсын чиг хандлагаас харахад хамтын санхүүжилт нь зөвхөн хандивын хэлбэрээс хөрөнгө оруулалт, зээл, токенжуулсан санхүүжилтийн хэлбэр лүү өргөжин хөгжиж байгаа бөгөөд платформ төвтэй нэгдсэн зохицуулалтын хэрэгцээ нэмэгдэж байна. Ялангуяа *European Union-д ECSP Regulation* хэрэгжиж эхэлснээр хил дамнасан хамтын санхүүжилтийн платформын үйл ажиллагаа, нэг лицензээр олон улсад үйлчилгээ үзүүлэх боломж нэмэгдсэн нь нэгдсэн зохицуулалтын загвар дэлхийд давамгайлах хандлагатай байгааг харуулж байна.

Нөгөө талаас хамтын санхүүжилтийн зах зээл тэлэхийн хэрээр хөрөнгө оруулагчийн хамгаалалт, ил тод байдлын шаардлага, платформын хариуцлага зэрэг асуудал чухал хөндөгдөнө. Тухайлбал, Франц улсын үл хөдлөх хөрөнгийн хамтын санхүүжилтийн салбарт зээлийн эргэн төлөлтийн хүндрэл, платформын ашигт ажиллагааны асуудал үүссэн нь зохицуулалтын үр нөлөө, хөрөнгө оруулагч хамгаалалтын асуудлыг дахин анхаарах шаардлагатайг харуулж байна. Хэт хурдтай өсөлт болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт нь хамтын санхүүжилтийн платформуудын эрсдэлийг нэмэгдүүлж, зарим тохиолдолд хөрөнгө оруулагчид хөрөнгөө хугацаанд нь буцаан авах боломжгүй нөхцөл үүсгэж байгаа нь зохицуулалтын үр нөлөө, платформын хариуцлагын асуудлыг чухалчлах шаардлагатайг харуулж байна.

Иймээс олон улсын туршлагаас хамтын санхүүжилтийн зохицуулалт нь зөвхөн инновацыг дэмжих бус, мөн:

- хөрөнгө оруулагчийн хамгаалалт,
- мэдээллийн ил тод байдал,
- платформын санхүүгийн чадавх,

- эрсдэлийн удирдлага,
- платформын хариуцлага зэрэг асуудлыг тэнцвэртэй зохицуулах шаардлагатай болж байна.

Өөрөөр хэлбэл хамтын санхүүжилтийн эрх зүйн орчин нь зөвхөн инновацыг дэмжих бус платформын хариуцлагатай байдал, мэдээллийн ил тод байдал, хөрөнгө оруулагчийн хамгаалалтыг тэнцвэртэй хангах чиглэлд хөгжиж байна.

Хамтын санхүүжилтийн үйлчилгээний зохицуулалт олон улсад:

Улс орнуудын хувьд мөн адил хувьцаанд суурилсан хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг хувьцаа, хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээлд хамаарах хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна.

Хүснэгт 1. Хамтын санхүүжилтийн үйлчилгээний зохицуулалт бүс нутгаар

Бүс нутаг	Гол улс орнууд	Зах зээлийн онцлог	Зохицуулалтын хандлага	Загвар
Хойд Америк	United States	Хамгийн том зах зээл, стартап санхүүжилт өндөр, платформууд төвлөрсөн	Хөрөнгө оруулагч хамгаалалт өндөр, үнэт цаасны хатуу зохицуулалт (SEC)	Салгасан + үнэт цаас төвтэй
Европ	European Union, Portugal, Finland	Нэгдсэн зах зээл, хил дамнасан платформ өсч байгаа	Нэгдсэн crowdfunding зохицуулалт (ECSP), нэг лицензийн систем	Нэгдсэн платформ төвтэй
Ази, Номхон далай	South Korea, Japan, Singapore	Хамгийн хурдан өсөлттэй, mobile fintech давамгайл	Холимог: зарим нь нэгдсэн, зарим нь салгасан зохицуулалт	Hybrid (холимог)
Латин Америк	Бразил, Мексик гэх мэт	Санхүүгийн хүртээмж бага, fintech өсөж буй	Зохицуулалт сул, хөгжиж буй шатанд	Сул зохицуулалттай
Африк, Ойрхи Дорнод	Кени, Нигери, UAE гэх мэт	Санхүүгийн хүртээмж маш бага, mobile-first	Хэсэгчилсэн зохицуулалт, стандарт жигд биш	Эхлэл шатны зохицуулалт

Манай улсад Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 50¹ дүгээр зүйл 50¹.3, 50¹.5, 63 дугаар зүйлийн 63.1.20-д тус тус заасны дагуу зөвхөн хувьцаанд суурилсан хамтын санхүүжилтийн харилцааг Санхүүгийн зохицуулах хороо 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журам”-аар зохицуулж байна. Харин хамтын санхүүжилтийн бусад төрөл буюу зээл, урамшуулал, хандивт суурилсан хамтын санхүүжилтийг зохицуулсан бие даасан хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Иймд хуулийн төслийг боловсруулахад бусад улсын хамтын санхүүжилтийн үйлчилгээтэй холбогдсон хууль тогтоомж, олон улсын туршлагыг судалж, олон улсын жишиг зохицуулалт болон өнгөрсөн хугацаанд манай улсад хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад бий болсон туршлага, хамтын санхүүжилтийн үйлчилгээнд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах хэрэгцээ шаардлага зэргийг харгалзсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн танилцуулгыг бэлтгэлээ.

Хуулийн төсөлд зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгалаа. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт: Нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт зэргийг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт: Хувьцаанд суурилсан, зээлд суурилсан, урамшуулалд суурилсан, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ, тэдгээрт тавих шаардлагыг тодорхойлон тусгана.

Гуравдугаар бүлэгт: Хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгч, түүнд тавигдах хүний нөөц, программ хангамж, эрх бүхий албан тушаалтнуудын шаардлага, хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, тайлан, мэдээлэл ирүүлэх хугацаа, программ хангамжид ил тод нээлттэй байршуулах мэдээлэл, хувьцаа болон зээлд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгчид олгох зөвшөөрөл түүнд ирүүлэх баримт бичиг, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт: Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгч өөрийн харилцагчид үнэн зөв, тодорхой, ойлгомжтой байдлаар өгөх мэдээлэл, гомдол хүлээн авах болон түүнийг шийдвэрлэх хугацаа зэргийг тусгана.

Тавдугаар бүлэгт: Хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгч нь баримт мэдээллийг хэрхэн хадгалах, үйлчилгээтэй холбоотой аливаа зар сурталчилгааг

харилцагчид төөрөгдөлгүй, тодорхой, ойлгомжтой байдлаар хүргэх болон мэдэгдлийн хүрээнд эрхлэх урамшуулал болон хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээнд хяналт тавих этгээд болон хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зэргийг тус тус тодорхойлно.

Хамтын санхүүжилтийн тухай анхдагч хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр нөлөөтэй байна:

- Гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг хямд зардлаар бий болгон бодит эдийн засгийн өсөлтийг хангана. Учир нь эдийн засагт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид чухал үүрэг гүйцэтгэдэг тул тэдгээрийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

- Гарааны компани болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүжилт татан төвлөрүүлэх илүү хялбар боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ иргэдийг хөрөнгийн зах зээлд бага хэмжээний хөрөнгөөр оролцох нөхцөлийг бий болгох, санхүүгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, инноваци, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал ач холбогдолтой.

- Зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавигдах хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэд болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгох зээлийн хэмжээ буурсан. Харин хамтын санхүүжилтийн үйлчилгээний эрх зүйн орчинг бүрдүүлснээр банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйлчилгээ хүрэх боломжгүй байгаа орон зайг нөхөх ач холбогдолтой.

- Онлайн платформд суурилсан үйл ажиллагаанд томоохон дэд бүтэц, их хэмжээний удирдлагын зардал шаардагдахгүй тул санхүүжилт хүсэгч этгээдийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах давуу талтай.

- Урамшуулал болон хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг зохицуулснаар санхүүжилт татан төвлөрүүлэх үйл ажиллагааны ил тод, найдвартай байдлыг хангахын зэрэгцээ залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, улмаар иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, эдийн засгийн цаашдын хөгжилд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

- Зээл болон хувьцаанд суурилсан хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулж буй дотоодын болон гадаад улсын хөрөнгө оруулагчийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүгийн зах зээлийн идэвхжил, хүртээмжийг өргөжүүлэх ач холбогдолтой.

- Монгол Улсын банкнаас бусад санхүүгийн салбарын бүтэц, төрөлжилтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

- Уламжлалт, барьцаанд суурилсан санхүүжилтийн шаардлагад нийцэхгүй шинэлэг төсөл, үйл ажиллагаанд бодит санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох замаар эдийн засгийн өсөлт, инновацын хөгжлийг дэмжих ач холбогдолтой.

- Цахим орчин дахь зохицуулалтгүй хөрөнгө татах үйл ажиллагааг хамтын санхүүжилтийн эрх зүйн орчинд оруулснаар залилангийн шинж чанартай хэт өндөр өгөөж амласан хөрөнгө татах үйл ажиллагааны эрсдэлийг бууруулж, маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх бодит механизм бүрдэх ач холбогдолтой.

- Хамтын санхүүжилтийн платформын хөгжил нь төлбөр тооцоо, дижитал баталгаажуулалт, өгөгдөлд суурилсан эрсдэлийн үнэлгээ зэрэг санхүүгийн технологийн хэрэглээг өргөжүүлэхийн зэрэгцээ санхүүгийн салбар дахь технологийн шинэчлэл, салбар дундын инновацыг дэмжих ач холбогдолтой.

Хамтын санхүүжилтийн үйлчилгээний зохицуулалтыг практик шаардлага, олон улсын судалгаа, сайн туршлагад нийцүүлж Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсрууллаа.

Мөн энэхүү хуулийн төсөлтэй хамт Хамтын санхүүжилтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл болон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.